



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2023 ОНЫ ЭХНИЙ 10 САРЫН ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo>
цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад
танилцуулга, мэдээтэй танилцана уу.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

2023 он | №10

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл: 2,061.5 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ. 2023 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал өмнөх оны мөн үеэс 3,080.4 тэрбум төгрөгөөр, төлөвлөсөн дүнгээс 3,563.9 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Төсвийн орлогын хувьд: 2023 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 18,961.9 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 811.8 тэрбум төгрөгөөр илүү биелсэн бол өмнөх оны мөн үеэс 5,995.1 тэрбум төгрөг буюу 46.2 хувиар нэмэгджээ.

- Төлөвлөгөөтэй харьцуулахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө тайлант хугацаанд 104.5 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого төлөвлөснөөс 811.8 тэрбум төгрөгөөр илүү биелсэн нь татварын орлого 6.4 хувь буюу 1,056.0 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс илүү биелсэнтэй холбоотой байна.
- Тайлант хугацаанд орлогын гадаад үйл ажиллагааны орлого, тусгай зориулалтын орлого болон онцгой албан татвараас бусад төрлийн татварын орлого 1.1-14.2 хувиар төлөвлөснөөс илүү биелсэн гүйцэтгэлтэй гарчээ.
- Татварын бус орлогын төлөвлөгөө 2023 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 244.1 тэрбум төгрөгөөр дутуу биелснээр 84.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь хувьцааны ногдол ашиг, торгуулийн орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого болон түрээсийн орлогоос бусад төрлийн татварын бус орлого төлөвлөсөнд хүрч биелээгүйтэй холбоотой байна.
- **Төсвийн нийт зарлагын хувьд:** Нэгдсэн төсвийн нийт зарлага 2023 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 16,900.4 тэрбум төгрөгт хүрч 2,752.0 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай буюу 86.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.
- Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг тайлант хугацааны төлөвлөгөөтэй харьцуулахад 14.0 хувиар дутуу зарцуулагдсан ч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20.8 хувиар буюу 2,914.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үеэс 308.7 тэрбум төгрөгөөр өссөн бол тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 67.8 тэрбум төгрөгийн буюу 6.2 хувиар дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2023 онд нийт 2,695.0 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. 2023 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 1,515.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 1,514.7 тэрбум төгрөгийг зарцуулж 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.


МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2023 ОНЫ ЭХНИЙ 10 САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2,061.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2023 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 18,961.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 16,900.4 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2,061.5 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ. Тайлант хугацаан дахь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал төлөвлөснөөс 3,563.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

График 1. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/



Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 46.2 хувь буюу 5,995.1 тэрбум төгрөгөөр, төсвийн нийт зарлага 20.8 хувь буюу 2,914.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, төсвийн зарлагын өсөлт орлогын өсөлтөөс 25.4 пунктээр бага гарсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 3,080.4 тэрбум төгрөгөөр буурахад нөлөөлжээ.

Хүснэгт 1. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Тэрбум төгрөгөөр

Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	ӨО-ны мөн үед	2023 оны эхний 10 сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь.	Зөрүү.
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-210.2	-412.2	1,682.0	408.1	2,094.2
Засгийн газрын бонд	-91.8	-569.6	828.3	145.4	1,397.9
Засгийн газрын зээл	-716.4	-130.7	-446.3	-341.4	-315.6
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	0.0	-386.9	0.0	0.0	386.9
Өмч хувьчлал	-0.5	-3.0	-2.5	-83.2	0.5
НИЙТ ДҮН	-1,018.9	-1,502.4	2,061.5	137.2	3,563.9

Эх сурвалж: Сангийн яам

2023 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 811.8 тэрбум төгрөг төлсөн бол 909.7 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл шинээр авч, 2.5 тэрбум төгрөгийн өмч хувьчлалын орлогыг төвлөрүүлж, урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 566.4 тэрбум төгрөг, урт хугацаат гадаад бондын үндсэн төлбөрт 2,517.9 тэрбум төгрөг төлсөн бол 2,256.0 тэрбум төгрөгийн гадаад бонд шинээр гаргасан байна.

2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

“ Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 18,961.9 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 46.2 хувь буюу 5,995.1 тэрбум төгрөгөөр, орлогын төлөвлөгөө 4.5 хувь буюу 811.9 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн байна.

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл нийгмийн даатгалын сан 0.9 хувь буюу 31.1 тэрбум төгрөгөөр, улсын төсөв 3.8 хувь буюу 479.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн бол, орон нутгийн төсөв 2.7 хувь буюу 99.8 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 2.7 хувь буюу 35.9 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс тус тус дутуу төвлөрчээ.

” Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 19.8 хувь буюу 213.2 тэрбум төгрөгөөр, улсын төсөв 72.0 хувь буюу 5,543.1 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сан 18.7 хувь буюу 531.2 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсөв 52.8 хувь буюу 1,234.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө төлөвлөснөөс дутуу төвлөрөхөд татварын бус орлого 15.5 хувь буюу 244.1 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нь гол нөлөө үзүүлжээ.


Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн орлогын 2023 оны эхний 10 сарын гүйцэтгэл, төсвийн шатлалаар

Тэрбум төгрөгөөр

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	13,530.9	14,059.1	3,674.9	3,575.1	3,338.7	3,369.8	1,324.8	1,288.9
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	386.9	612.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	12,765.8	13,245.6	3,674.9	3,575.1	3,338.7	3,369.8	1,324.8	1,288.9
Татварын орлого	10,791.2	11,826.0	2,734.9	2,721.8	2,702.4	2,743.4	1,324.8	1,288.9
Орлогын албан татвар	2,034.1	2,856.6	2,082.4	2,070.1	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	2,702.4	2,743.4	1,324.8	1,288.9
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	278.3	309.6	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	3,808.0	3,777.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	772.8	660.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	17.6	17.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	1,321.9	1,189.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	2,836.7	3,324.6	374.1	342.2	0.0	0.0	0.0	0.0
Татварын бус орлого	1,974.6	1,419.6	940.0	853.2	636.4	626.4	0.0	0.0
Нийтлэг татварын бус орлого	845.6	749.3	401.5	336.6	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	6.9	5.3	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	293.2	224.3	26.0	14.2	636.4	626.4	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	835.9	446.0	505.6	497.1	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

График 2. Нэгдсэн төсвийн орлогын бүтэц /Хувиар/



Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 93.0 хувийг татварын орлого, 7.0 хувийг татварын бус орлого эзэлж байна.




Татварын орлого 17,634.6 тэрбум төгрөг болж, орлогын төлөвлөгөө 6.4 хувь буюу 1,056.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 6.4 хувь буюу 1,056.0 тэрбум төгрөгөөр өссөн бол, татварын бус орлого 15.5 хувь буюу 244.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.



Татварын орлогын 27.9 хувийг орлогын албан татвар, 17.5 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.8 хувийг хөрөнгийн албан татвар, 21.4 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 3.7 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 6.7 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 20.8 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

График 3. Татварын орлого /Тэрбум төгрөгөөр/



Тайлант хугацаанд татварын орлого төлөвлөснөөс 47.3 хувь буюу 5,995.1 тэрбум төгрөгөөр давуулан биелэхэд орлогын албан татвар 19.7 хувь (810.2 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 11.2 хувиар (31.3 тэрбум төгрөг) тус тус төлөвлөснөөс давуулан биелсэн нь нөлөөлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2023 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр татварын орлого 47.3 хувь буюу 5,663.5 тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 75.7 хувь (2,122.6 тэрбум төгрөг)-аар, нийгмийн даатгалын орлого 30.4 хувь (719.9 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 70.8 хувь (128.3 тэрбум төгрөг), нэмэгдсэн өртгийн албан татвар 20.4 хувь (640.3 тэрбум төгрөг), гадаад үйл ажиллагааны орлого 12.5 хувь (132.5 тэрбум төгрөг), -аар тус тус өссөн нь нөлөөлжээ.

“


Татварын бус орлого 1,327.3 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 331.6 тэрбум төгрөгөөр өссөн бол төлөвлөснөөс 244.1 тэрбум төгрөг буюу 15.5 хувиар дутуу биелжээ.

”

Төлөвлөгөөтэй харьцуулахад торгуулийн орлого 17.7 тэрбум төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 71.9 тэрбум төгрөгөөр, хувьцааны ногдол ашиг 4.9 тэрбум төгрөгөөр тус тус давж биелжээ.

Харин хүүгийн орлого 50.5 тэрбум төгрөгөөр, газрын тосны орлого 47.9 тэрбум төгрөг, навигацийн орлого 106.9 тэрбум төгрөг, бусад орлого 51.2 тэрбум төгрөгөөр, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 1.6 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн байна.

График 4. Татварын бус орлогын бүтэц /Хувиар/



Татварын бус орлогын 81.8 хувийг нийтлэг татварын бус орлого, 17.2 хувийг тусламжийн орлого, 0.4 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна.

Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 14.2 хувийг хүүгийн орлого, 5.3 хувийг торгуулийн орлого, 23.2 хувийг газрын тосны орлого, 34.8 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 0.4 хувийг түрээсийн орлого эзэлсэн бол 8.1 хувийг бусад орлого бүрдүүлж байна.



Татварын ерөнхий газар орлогын төлөвлөгөөг 19.0 хувиар давуулж, Гаалийн ерөнхий газар 6.0 хувиар дутуу биелүүлсэн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн дагуу нийт 21 төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээсний 11 нь төлөвлөсөн орлогыг давуулан биелүүлсэн бол үлдсэн 9 нь 4.2-82.6 хүртэл хувиар дутуу төвлөрүүлсэн гүйцэтгэлтэй байна.



Хүснэгт 3. 2023 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр улсын төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого

Сая төгрөгөөр

Төсвийн ерөнхийлөн захирагч	ӨО-ны мөн үеийн	2023 оны эхний 10 сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
Сангийн сайд	9,138,875.0	12,773,114.2	13,857,835.2	1,084,721.0	108.5
Татварын ерөнхий газар	5,435,354.3	7,715,291.9	9,182,675.4	1,467,383.5	119.0
Үүнээс: Тогтворжуулалтын санд	1,032,302.4	487,080.2	612,788.8	125,708.6	125.8
Гаалийн ерөнхий газар	3,421,243.6	4,603,489.8	4,328,001.5	-275,488.3	94.0
Сангийн яам	77,439.3	159,475.8	119,532.5	-39,943.3	75.0
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	198,966.0	291,415.8	221,940.8	-69,475.0	76.2
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,871.7	3,440.9	5,685.0	2,244.1	165.2
Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга	122.0	154.2	123.3	-30.8	80.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	122.0	154.2	123.3	-30.8	80.0
Монгол Улсын Ерөнхий сайд		143.8	136.0	-7.8	94.6
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар		143.8	136.0	-7.8	94.6
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	159,571.7	403,884.3	234,083.2	-169,801.1	58.0
Монгол Улсын Их Хурлын дарга	158,010.0	403,188.0	232,651.7	-170,536.3	57.7
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,561.7	696.3	1,431.4	735.1	205.6
Монгол Улсын Шадар сайд	13,002.7	13,243.9	18,783.6	5,539.7	141.8
Стандартчилал хэмжилзүйн газар		1,000.0	648.1	-351.9	0.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	13,002.7	12,243.9	18,135.5	5,891.6	148.1
Хууль зүй, дотоод хэргийн сайд	41,348.4	41,678.7	52,284.4	10,605.7	125.4
Улсын бүртгэлийн ерөнхий газар	14,859.6	16,387.2	17,907.9	1,520.7	109.3
Цагдаагийн ерөнхий газар	1,426.8	4,166.7	1,839.8	-2,326.9	44.2
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	923.1	1,120.3	1,040.8	-79.6	92.9
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	24,138.9	20,004.6	31,496.0	11,491.4	157.4
Гадаад харилцааны сайд	881.7	4,234.8	15,387.1	11,152.2	363.3
Дипломат төлөөлөгчийн газрууд	881.7	4,234.8	15,387.1	11,152.2	363.3
Зам, тээврийн хөгжлийн сайд	28,242.4	127,052.5	22,091.8	-104,960.7	17.4
Иргэний нисэхийн ерөнхий газар	16,000.0	108,250.0	1,400.0	-106,850.0	1.3
Зам, тээврийн хөгжлийн яам	185.0	202.5	140.0	-62.5	69.1
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	12,057.4	18,600.0	20,551.8	1,951.8	110.5
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	154,832.3	351,798.0	331,969.1	-19,828.9	94.4
Ашигт малтмал, газрын тосны газар	153,127.3	349,438.8	329,480.8	-19,958.0	94.3
		92.0	153.6	61.6	166.9
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,705.0	2,267.2	2,334.8	67.6	103.0
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	32,572.7	39,414.9	60,688.0	21,273.2	154.0
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	292.5	508.1	508.0	-0.1	100.0
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	1,343.2	665.3	1,344.7	679.4	202.1
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	30,937.0	38,241.5	58,835.3	20,593.9	153.9
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	46,675.9	44,318.1	45,102.2	784.1	101.8
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	46,675.9	44,318.1	45,102.2	784.1	101.8

Эрүүл мэндийн сайд	7,209.0	4,124.0	6,413.9	2,289.9	155.5
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	7,209.0	4,124.0	6,413.9	2,289.9	155.5
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	3,284.9	716.3	8,126.5	7,410.2	1134.5
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	3,284.9	716.3	8,126.5	7,410.2	1134.5
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	335.2	133.0	340.3	207.3	255.9
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	335.2	133.0	340.3	207.3	255.9
Боловсрол, шинжлэх ухааны сайд	4,494.1	5,592.1	4,899.4	-692.7	87.6
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	4,494.1	5,592.1	4,899.4	-692.7	87.6
Барилга, хот байгуулалтын сайд	850.0	1,773.2	1,216.9	-556.3	68.6
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	850.0	1,773.2	1,216.9	-556.3	68.6
Батлан хамгаалахын сайд	43,314.5	31,691.5	30,367.0	-1,324.5	95.8
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	43,314.5	31,691.5	30,367.0	-1,324.5	95.8
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	367.9	225.0	482.1	257.1	214.3
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	367.9	225.0	482.1	257.1	214.3
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	2,721.1	2,281.4	3,922.1	1,640.7	171.9
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,721.1	2,281.4	3,922.1	1,640.7	171.9
Эдийн засгийн хөгжлийн сайд	572.0	203.1	71.5	-131.7	0.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	572.0	203.1	71.5	-131.7	0.0
Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	8,242.4	7,222.7	12,424.3	5,201.6	172.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	8,242.4	7,222.7	12,424.3	5,201.6	172.0

Эх сурвалж: Сангийн яам



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 2,914.7 тэрбум төгрөг буюу 20.8 хувиар нэмэгдэж 16,900.4 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.



3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 19,652.5 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 86.0 хувийг зарлагдаж 2,752.0 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ.

Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн зарлагын 2023 оны эхний 10 сарын гүйцэтгэл /төсвийн шатлалаар/

Тэрбум төгрөгөөр

Зардлын зүйл	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,218.4	12,027.68	4,664.1	2,754.5	3,346.9	3,276.8	1,377.2	1,358.8
НИЙТ ЗАРЛАГА	13,186.0	11,872.2	4,585.3	2,702.9	3,398.2	3,277.5	1,377.2	1,358.8
УРСГАЛ ЗАРДАЛ	10,463.2	9,383.65	2,794.3	1,874.4	3,398.2	3,277.5	1,377.2	1,358.8
Бараа, ажил, үйлчилгээний зардал	3,159.9	2,587.8	1,497.4	1,141.4	35.6	30.6	8.7	7.3
Зээлийн үйлчилгээний төлбөр	1,047.7	1,017.7	45.5	7.6	0.0	0.0	0.0	0.0
Татаас	946.3	818.9	210.2	165.7	0.0	0.0	75.0	72.1
Урсгал шилжүүлэг	5,282.3	4,959.0	1,041.3	559.7	3,362.6	3,246.9	1,293.6	1,282.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,749.7	2,488.7	1,791.0	828.5	0.0	0.0	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	32.5	155.6	78.8	51.6	-51.3	-0.8	0.0	-3.4
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-452.6	1,217.9	-989.2	820.6	-8.2	93.0	-52.4	-70.0

Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд төлөвлөснөөс улсын төсвийн зарлага 1,190.7 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 1,909.6 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 70.1 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 18.4 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 20.8 хувь буюу 2,914.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд хөрөнгийн зардал 858.2 тэрбум төгрөгөөр, урсгал зардал 1,987.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 308.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 6.2 хувь буюу 67.8 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулалттай гарсан бол татаас, урсгал шилжүүлгийн зардал өмнөх оноос 925.1 тэрбум төгрөг буюу 11.8 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 5. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн гүйцэтгэл /зардлын эдийн засгийн ангиллаар/

Тэрбум төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	ӨО-ны мөн үе	2023 оны эхний 10 сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,985.7	19,652.5	16,900.4	86.0	-2,752.1
НИЙТ ЗАРЛАГА	13,851.4	19,592.5	16,697.4	85.2	-2,895.1
УРСГАЛ ЗАРДАЛ	11,392.3	15,051.7	13,380.2	88.9	-1,671.5
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,860.9	4,521.5	3,614.9	79.9	-906.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,348.9	1,976.3	1,765.0	89.3	-211.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	230.3	336.2	279.6	83.2	-56.5
Хангамж, бараа материалын зардал	135.5	174.2	149.4	85.7	-24.8
Нормативт зардал	167.3	204.4	169.5	82.9	-35.0
Эд хогшил, урсгал засварын зардал	80.2	138.5	95.0	68.6	-43.5
Томилолт, зочны зардал	20.8	50.9	35.9	70.5	-15.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	536.5	1,021.5	695.1	68.0	-326.4
Бараа үйлчилгээний бусад зардал	341.3	619.5	425.4	68.7	-194.0
ХҮҮ	716.7	1,093.2	1,025.4	93.8	-67.8
ТАТААС	443.9	595.1	430.3	72.3	-164.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,370.9	8,841.9	8,309.6	94.0	-532.3
Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,790.9	3,070.3	2,909.3	94.8	-161.0
Бусад урсгал шилжүүлэг	3,580.4	5,771.6	5,400.3	93.6	-371.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,459.0	4,540.8	3,317.2	73.1	-1,223.6
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	134.4	60.0	203.0	338.5	143.0


Эх сурвалж: Сангийн яам

“**Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд урсгал зардлын эзлэх хувийн жин 79.2 хувьд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 2.3 пунктээр буурсан байна.**”

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 79.2 хувь буюу 13,380.2 тэрбум төгрөг нь урсгал зардал бөгөөд нийт урсгал зардлын 62.1 хувийг урсгал шилжүүлэг, 27.0 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 7.7 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.2 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 1,630.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: татаас 9.9 тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч урсгал шилжүүлэг 643.6 тэрбум, бараа, ажил үйлчилгээний зардал 664.0 тэрбум, зээлийн үйлчилгээний төлбөр 332.6 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

График 5. Урсгал зардлын бүтэц /Хувиар/



“**Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар 37 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв зарцуулах эрхийг баталсан бөгөөд 2023 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр улсын төсвийн нийт зарлага 1,190.7 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж 91.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.**”

Төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлагын 21.4 хувийг Сангийн сайдын багц, 20.7 хувийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын багц, 21.2 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 9.4 хувийг Эрүүл мэндийн сайдын багц, 6.0 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, үлдэх 21.3 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын зардал эзэлж байна.

Хүснэгт 6. Улсын төсвийн нийт зардал, төсвийн ерөнхийлөн захирагчаар

Сая төгрөгөөр

Төсвийн ерөнхийлөн захирагч	2023 оны эхний 10 сарын гүйцэтгэл			
	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
Монгол Улсын Ерөнхийлөгч	22,462.7	17,592.5	4,870.2	78.3
Улсын Их Хурлын дарга	57,147.4	49,170.1	7,977.3	86.0
Үндсэн хуулийн цэцийн дарга	2,955.3	2,588.3	366.9	87.6
Улсын дээд Шүүхийн ерөнхий шүүгч	8,636.0	7,064.4	1,571.5	81.8
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	76,863.6	65,988.9	10,874.7	85.9
Улсын ерөнхий прокурор	60,981.4	54,402.6	6,578.9	89.2
Үндэсний аюулгүй байдлын зөвлөл	13,903.6	12,329.6	1,574.0	88.7
Монгол Улсын Ерөнхий сайд	221,213.2	150,334.0	70,879.3	68.0
Монгол Улсын Шадар сайд	177,901.1	146,535.4	31,365.7	82.4
Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	60,922.5	41,022.7	19,899.8	67.3
Сангийн сайд	3,109,080.8	2,788,395.3	320,685.5	89.7
Хууль зүй, дотоод хэргийн сайд	755,088.6	706,797.6	48,291.0	93.6
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	115,924.8	89,722.4	26,202.4	77.4
Батлан хамгаалахын сайд	305,519.7	275,152.7	30,367.0	90.1
Боловсрол, шинжлэх ухааны сайд	2,398,395.6	2,247,659.3	150,736.3	93.7
Гадаад харилцааны сайд	133,827.3	89,209.5	44,617.8	66.7
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	29,566.2	26,460.1	3,106.0	89.5
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	297,099.3	253,763.5	43,335.9	85.4
Эрүүл мэндийн сайд	1,073,543.8	1,022,546.9	50,996.9	95.2
Төрийн албаны зөвлөлийн дарга	3,125.5	2,083.8	1,041.7	66.7
Сонгуулийн ерөнхий хорооны дарга	3,293.1	2,636.7	656.4	80.1
Хүний эрхийн үндэсний хорооны дарга	4,251.4	3,604.1	647.2	84.8
Монгол Улсын ерөнхий аудитор	23,347.6	20,966.8	2,380.8	89.8
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	7,643.4	6,224.0	1,419.5	81.4
Үндэсний Статистикийн газрын дарга	16,350.4	14,132.0	2,218.4	86.4
ЦАУЗБУК-ын дарга	15,010.7	14,935.5	75.2	99.5
Зам, тээврийн хөгжлийн сайд	308,434.1	301,432.4	7,001.8	97.7
Барилга, хот байгуулалтын сайд	231,525.8	220,263.3	11,262.5	95.1
Эрчим хүчний сайд	180,919.9	159,909.2	21,010.7	88.4
Авлигатай тэмцэх газар	29,045.6	22,805.2	6,240.3	78.5
Соёлын сайд	228,082.4	212,651.4	15,431.0	93.2
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	149,672.8	149,672.8	0.0	100.0
Нийслэл УБ хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороо	2,975.2	2,359.9	615.3	79.3
Шүүхийн сахилгын хорооны дарга	216,876.1	189,206.3	27,669.9	87.2
Эдийн засаг, хөгжлийн сайд	53,668.6	41,628.0	12,040.7	77.6
Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	88,911.9	78,602.3	10,309.5	88.4
Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хороо дарга	3,618.1	2,455.6	1,162.6	67.9
Боомтын сэргэлтийн үндэсний хороо дарга	149,672.8	149,672.8	0.0	100.0
НИЙТ ЗАРДАЛ	13,218,447.7	12,027,763.0	1,190,684.7	91.0

Эх сурвалж: Сангийн яам

2023 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 1,515.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 1,514.7 тэрбум төгрөгийг зарцуулж 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2023 онд нийт 2,695.0 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. 2023 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 1,515.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 1,514.7 тэрбум төгрөгийг зарцуулж 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Хүснэгт 7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл /Төсвийн ерөнхийлөн захирагчаар/

Сая төгрөгөөр

Хуулийн дугаар	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	2023 оны төсөв	2023 оны эхний 10 сарын гүйцэтгэл			
			Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
I	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	7,543.8	3,118.8	3,118.8	0.0	100.0
II	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	43,193.8	7,738.1	7,738.1	0.0	100.0
III	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	23,091.1	11,391.8	11,391.8	0.1	100.0
IV	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	18,492.1	9,607.1	9,606.2	0.9	100.0
V	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	11,865.6	2,675.1	2,675.1	0.0	100.0
VI	САНГИЙН САЙД	201,894.5	65,383.5	65,383.5	0.0	100.0
VII	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	60,098.1	38,331.4	38,331.4	0.0	100.0
VIII	ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	36,841.3	22,945.3	22,945.2	0.1	100.0
IX	БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	345,152.5	192,582.4	192,487.6	94.7	100.0
X	БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	529,281.5	349,357.1	349,234.8	122.2	100.0
XI	СОЁЛЫН САЙД	144,237.3	85,951.1	85,906.4	44.7	99.9
XII	ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	408,821.9	249,057.5	249,054.9	2.5	100.0
XIII	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	74,672.5	45,458.7	45,457.6	1.1	100.0
XIV	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	168,999.2	104,996.7	104,996.7	0.0	100.0
XV	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	172,118.7	114,171.6	114,023.3	148.3	99.9
XVI	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	13,093.9	13,054.7	13,054.7	0.1	100.0
XVII	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	458.0	436.0	436.0	0.0	100.0
XVIII	ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	21,625.9	15,537.6	15,537.6	0.0	100.0
XIX	МОНГОЛ УЛСЫН САЙД, ОЛИМП, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	48,823.2	33,448.8	33,446.5	2.3	100.0
XX	МОНГОЛ УЛСЫН САЙД, НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	339,743.2	149,672.8	149,672.8	0.0	100.0
XXI	СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	15,967.1	189.0	189.0	0.0	100.0
	НИЙТ	2,686,015.3	1,515,105.3	1,514,688.2	417.1	100.0

Эх сурвалж: Сангийн яам

“Барих-шилжүүлэх” концесс

Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд “Барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлэхээр 279.6 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг Монгол Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төсөвлөснөөс эхний 10 сарын байдлаар 190.6 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тусгаж 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Хүснэгт 8. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх барих-шилжүүлэх концессын төрлөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн 2023 оны эхний 10 сарын гүйцэтгэл /төсвийн ерөнхийлөн захирагчаар/

Сая төгрөгөөр


ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны төсөв	2023 оны эхний 10 сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	279,590.4	194,597.2	194,597.2	0.0	100.0
Концессын төслийн эргэн төлөлт	279,590.4	194,597.2	194,597.2	0.0	100.0
I.Барилга байгууламж	279,590.4	194,597.2	194,597.2	0.0	100.0
Шилжих	279,590.4	194,597.2	194,597.2	0.0	100.0
Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төсөл	96,143.7	96,059.6	96,059.6	0.0	100.0
Дархан-Эрдэнэтийн авто замаас Сант сум, Орхон сум чиглэлийн 22.2 км хатуу хучилттай авто зам	15,040.0	14,870.8	14,870.8	0.0	100.0
Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн агаарын шугам, дэд станц төсөл/ Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц/	77,112.9	0.0	0.0	0.0	-
Өмнөговь аймгийн төвийг нийслэлтэй холбосон авто замын “Шар тээг”-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто зам төсөл	91,293.8	83,666.9	83,666.9	0.0	100.0

Эх сурвалж: Сангийн яам



5. Нийгмийн даатгалын сан

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

/Тэрбум төгрөгөөр/



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН



↑ -Өөрчлөлт (Өнгөрсөн оны мөн үеэс)


Монгол Улсын 2023 оны эхний 10 сарын гүйцэтгэл

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс

Нийгмийн даатгалын сангийн зарлагад 3,276.8 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 479.6 тэрбум төгрөг буюу 17.1 хувиар өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэврийн даатгалын сангийн зарлага 416.6 тэрбум төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 37.3 тэрбум төгрөгөөр, ҮОМШӨ-ий даатгалын сангийн зарлага 6.5 тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 28.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

2023 оны 10 дугаар сарын гүйцэтгэлээр нийгмийн даатгалын санд нийт 3,369.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөснөөс 0.9 хувь буюу 31.1 тэрбум төгрөгөөр давж биелэн жилийн орлогын гүйцэтгэл 80.7 хувьтай гарсан байна.


График 6. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлагын бүтэц /Хувиар/



6. Эрүүл мэндийн даатгалын сан

“ Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 2.3 хувиар дутуу биелжээ. ”


График 7. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого /Тэрбум төгрөгөөр/



Эрүүл мэндийн даатгалын санд 2023 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 1,288.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөснөөс 2.7 хувь буюу 35.9 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна.

“ Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,217.2 тэрбум төгрөгийн зарлага хийгдэж өнгөрсөн оны мөн үеэс 129.1 тэрбум төгрөгөөр буурсан байна. ”

График 8. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага /Тэрбум төгрөгөөр/



2023 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 1,377.2 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж, 1,358.8 тэрбум төгрөгийг зарцуулж, тус сангийн гүйцэтгэл 98.7 хувьтай гарчээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тус сангийн нийт зарлага 59.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

2023 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн зарлага 1,909.6 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

7. Орон нутгийн төсөв

2023 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлого 3,575.1 тэрбум төгрөг болж төлөвлөсөн дүнгээс 2.7 хувь буюу 99.8 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн бол орон нутгийн төсвийн нийт зарлага 2,754.5 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 40.9 хувь буюу 1,909.6 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж, орон нутгийн төсвийн тэнцэл 820.6 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 52.8 хувиар буюу 1,234.9 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн нийт зарлага 46.6 хувь буюу 876.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогын 86.1 хувийг орон нутгийн төсвийн орлого, 5.8 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, 8.1 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг эзэлж байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 208.1 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөгдөж 100 хувийн гүйцэтгэлтэй, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэгт 297.4 тэрбум төгрөгийг шилжүүлэхээр төсөвлөгдөж 289.0 тэрбум төгрөгийг шилжүүлж, 97.2 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Хүснэгт 8. Аймгуудад улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, аймгийн тусгай зориулалтын болон орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг

Сая төгрөгөөр

АЙМАГ	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	16,983.4	16,983.4	100.0	8,608.2	8,400.8	97.6
Баян-Өлгий	10,235.1	10,235.1	100.0	8,042.7	7,885.4	98.0
Баянхонгор	18,771.2	18,771.2	100.0	12,444.0	12,262.6	98.5
Булган	8,677.5	8,677.5	100.0	7,486.3	7,181.8	95.9
Говь-Алтай	15,071.3	15,071.3	100.0	12,055.7	11,748.4	97.5
Дорноговь	0.0	0.0	0.0	21,686.0	20,111.9	92.7
Дорнод	0.0	0.0	0.0	17,471.3	16,270.2	93.1
Дундговь	13,665.7	13,665.7	100.0	9,597.4	9,090.6	94.7
Завхан	18,455.8	18,455.8	100.0	12,028.7	11,804.2	98.1
Өвөрхангай	17,611.3	17,611.3	100.0	9,824.6	9,619.6	97.9
Өмнөговь	0.0	0.0	0.0	22,953.2	22,608.2	98.5
Сүхбаатар	7,895.1	7,895.1	100.0	13,751.3	13,485.7	98.1
Сэлэнгэ	0.0	0.0	0.0	16,382.6	16,250.6	99.2
Төв	9,436.0	9,436.0	100.0	16,585.5	16,339.2	98.5
Увс	16,567.8	16,567.8	100.0	9,062.6	8,861.3	97.8
Ховд	10,159.1	10,159.1	100.0	15,375.0	15,201.6	98.9
Хөвсгөл	21,512.4	21,512.4	100.0	11,602.0	11,415.7	98.4
Хэнтий	21,146.6	21,146.6	100.0	10,637.3	10,298.9	96.8
Дархан-Уул	0.0	0.0	0.0	10,832.5	10,726.9	99.0
Улаанбаатар	0.0	0.0	0.0	32,696.2	32,111.3	98.2
Орхон	0.0	0.0	0.0	13,684.8	13,517.8	98.8
Говьсүмбэр	1,937.5	1,937.5	100.0	4,632.0	3,825.9	82.6
ДҮН	208,125.8	208,125.8	100.0	297,439.7	289,018.6	97.2

Эх сурвалж: Сангийн яам

График 9. Орон нутгийн төсвийн орлогын бүтэц /Хувиар/



Орон нутгийн нийт орлого төлөвлөснөөс 99.8 тэрбум төгрөг буюу 2.7 хувиар дутуу төвлөрсөн нь ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 8.4 тэрбум төгрөгөөр дутуу шилжүүлж, орон нутгийн орлого 2.9 хувь буюу 91.4 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

Орон нутгийн орлогыг аймгуудаар харуулбал: Архангай аймаг 348.6 сая, Баян-Өлгий аймаг 822.2 сая, Баянхонгор аймаг 685.4 сая, Булган аймаг 405.6 сая, Говь-Алтай аймаг 213.8 сая, Дорноговь аймаг 31,423.0 сая, Дорнод аймаг 7,205.5 сая, Дундговь аймаг 751.3 сая, Өмнөговь аймаг 87,674.7 сая, Сүхбаатар аймаг 14,212.2 сая, Сэлэнгэ аймаг 7,912.7 сая, Увс аймаг 66.6 сая, Хэнтий аймаг 72.2 сая, төгрөгөөр төлөвлөгөөг дутуу биелүүлсэн бол Завхан аймаг 2,496.1 сая, Өвөрхангай аймаг 484.1 сая, Төв аймаг 2,810.4 сая, Ховд аймаг 4,929.9 сая, Хөвсгөл аймаг 673.0 сая, Дархан-Уул аймаг 4,672.0 сая, Улаанбаатар хот 33,391.4 сая, Орхон аймаг 2,223.3 сая, Говьсүмбэр аймаг 319.2 сая төгрөгөөр тус тус төлөвлөснөөс илүү төвлөрүүлсэн байна.